

ПРЕМИУМ КАСТОМС ХХК-ИЙН
ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
(Өмнөговь аймаг, Ханбогд сүм)

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

ОРШИЛ III

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2.1 Төслийн байршил, орчны тойм зураг	1-1
1.2.2 ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГУУЛАМЖУУД.....	1-2
1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО	1-3
1.4 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	1-3
1.5 ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ	1-3
1.6 ХОГ ХАЯГДАЛ	1-4
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	2-1
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТЗ-3	
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-3
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-3
3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-3
3.4 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	3-3
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-1
4.1 ГОЛ ЗОРИЛТ	4-1
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ	4-1
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-1
4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-4
4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	4-4
4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-4
4.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4-5
4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	4-6
4.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-8
4.9.1 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-8
ДҮГНЭЛТ А	
ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	B

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Төслийн булангийн цэгийн координат.....	1-1
Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	4-1
Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4-2
Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө	4-4
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	4-5
Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	4-5
Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4-7
Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	4-8
Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайлagnah хуваарь	4-9
Зургийн жагсаалт	
Зураг 1-1. Төслийн талбайн байршил	1-1
Зураг 1-2. Төслийн талбайн зураг төсөл	1-2
Зураг 1-3. Төслийн талбайн фото зураг	1-2
Зураг 1-4. Төслийн талбайн фото зураг	1-3

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Премиум кастомс ХХК-ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2021.07.24-ний өдрийн 13/3235 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2021 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн үйл ажиллагаатай холбогdon бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд энэхүү 2024 оны БОМТ нь 2021 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн эхний жилийн БОМТ юм.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлэх Премиум Кастомс ХХК-ийн Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none">Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Премиум Кастомс ХХКУлсын бүртгэлийн дугаар: 9011722073Регистрийн дугаар: 6274462Хаяг: Хан-Уул, 15-р хороо, хүннү-2222,117,11-02 тоот.Утас: +976 9999 8398Цахим шуудан: premiumcustomsllc@gmail.com


1.2 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Төслийн байршил, орчны тойм зураг

Премиум кастомс ХХК-ийн Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд нийт 15 га талбайд хэрэгжихээр төлөвлөж байна. Төслийн талбайн солбицлын цэгүүдийг Хүснэгт 1-1-д, байршлыг Зураг 1-1-т тусгав.

Хүснэгт 1-1. Төслийн булангийн цэгийн координат

№	X	Y	Урт
1.	707224.12	4717613.35	228.88
2.	707097.98	4717804.36	203.45
3.	707269.60	4717913.67	485.20
4.	707678.92	4718174.32	212.31
5.	707787.23	4717991.68	200.00
6.	707620.59	4717881.04	212.03
7.	707444.00	4717763.64	266.30




Зураг 1-1. Төслийн талбайн байршил

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

Төслийн байршил нь Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 км, Гашуун Сухайтын хилийн боомтоос 24 км зайд байрлана.

1.2.2 ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГУУЛАМЖУУД

Премиум кастомс ХХК-ийн Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл нь барилга байгууламжийн хувьд гаалийн хяналтын талбайн хашаа, пүү, пүүний барилга зэргээс бүрдэнэ (Зураг 1-2).



Зураг 1-2. Төслийн талбайн зураг төсөл

Төслийн талбайн өнөөгийн фото зургийг Зураг 1-3, Зураг 1-4-т тусгав.



Зураг 1-3. Төслийн талбайн фото зураг



Зураг 1-4. Төслийн талбайн фото зураг

Төсөл хэрэгжих нийт 15 га талбайн 3 га талбайд ажилчдын кемп, 3 га талбайд авто зогсоол байгуулж үлдсэн 9 га талбайд нүүрс ачиж буулгах талбай байгуулах юм. Үүнээс 3 га талбай нь орц, гарцын хэсэг байна.

1.3 ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багт өөрийн эзэмшлийн 15 га талбайд гаалийн хяналтын талбай байгуулж ажиллах бөгөөд үлс хоорондын ачаа тээвэрлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах ач холбогдолтой.

1.4 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл нь нэг удаад 2.5 сая тонн, жилд 12-15 сая тонн нүүрс буулгах хүчин чадалтай бөгөөд North benz маркийн нийт 30 тээврийн хэрэгсэлтэй байх бөгөөд 1 машин дунджаараар 110 тн нүүрс зөөх хүчин чадалтай. Төслийн талбайд талбайн эрхлэгч, талбайн зохион байгуулагч, гаалийн мэдүүлэгч, гаалийн бүрдүүлэлт хийх мэргэжилтэн, пүүний мэдүүлэгч, пүүчин, ковшчин, бүтээлэг бүтээгч, хүний нөөцийн менежер, нягтлан бодогч, ХАБЭА-н ажилтан, тогооч, аж ахуйн нярав зэрэг нийт 13 хүн гаалийн ерөнхий газрын цагийн хуваарийн дагуу ажиллана.

1.5 ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж: Гаалийн хяналтын талбайн цахилгааны хэрэглээг 24 цагийн генератор ажиллуулахаар төлөвлөж байна.

Дулаан хангамж: Дулаан хангамжийн хувьд ажилчдын кемпийн барилгыг нам даралтын зуухаар хангахаар төлөвлөж байна.

Усан хангамж: Ажилчдын унд ахуйн усыг Ханбогд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлалтай “Булан сухай”-н худгаас зөөвөрлөн хэрэглэх ба усыг зөөвөрлөх эрх бүхий хүнээр зөөвөрлөн ашиглахаар гэрээ хийсэн байна.

1.6 ХОГ ХАЯГДАЛ

Ахуйн хог хаягдал. Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын ахуйн гаралтай хог болон машин техникээс сольсон тос, сэлбэг хэрэгслийн гаралтай хаягдал гарна. Нийт 13 ажилтантай учир хог хаягдлын тооцоог 13 хүнээр тооцов. Хог хаягдлын тооцоог гаргахдаа нэг хүн өдөрт 0.5 кг ахуйн хог хаягдал гаргана гэж тооцоолоход хоногт 6.5 кг, жилд 2,372.5 кг хатуу хаягдал гарахаар байна.

Усны хэрэглээ ба шингэн хаягдал. Ажилчдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт ахуйн бохир шингэн хаягдал гарна. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар батлагдсан орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн нэг хүний усны хэрэглээний нормыг тооцоолоходо худаг булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хорооллын нормын дагуу нэг хүн хоногт дунджаар 20литр ус хэрэглэн гэж тооцов. Хоногт 260 л буюу 0.26 м^3 , жилд 94,900 л буюу 94.9 м^3 ус хэрэглэхээр байна. Үүний 70%-ийг шингэн хаягдал болно гэж үзвэл хоногт 66,430 л буюу 66.4 м^3 шингэн хаягдал гарахаар байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл. Өмнөговь аймгийн Ханбогд сүм нь Монгол орны физик газарзүйн мужлалын ангиллаар (Даш 1999, 2015) Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж, Дорнод говийн мужид хамаарна. Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж нь 657614.5км² талбайг эзлэх бөгөөд талбайн хэмжээгээр хамгийн том муж юм. Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж нь нийт талбайн 42 хувийг эзлэх бөгөөд үүний 15 хувийг Дорнод говийн муж эзэлнэ. Төв Азийн заримдаг цөл, цөлийн их муж нь Алтайн ар болоод өвөр говь, Говь-Алтайн нуруу, говийн дорнод хэсэг багтах бөгөөд гадарга нь урт удаан хугацааны туршид элэгдэл, эвдрэлд гүн өртсөн, цөлийн гандааст автан харлаж, өгөршлийн улмаас элдэв дүрс хэлбэртэй болсон, гадаргын ус ховор, гандуу, хуурай уур амьсгалын нөхцөлд үүсэж тогтвортжсон цөлжүү хээр, заримдаг цөл, хээржүү цөл, өмнөдийн цөл, хэт гандуу цөлийн ландшафт тархана [1].

Цаг уур, уур амьсгал. Энэ бүс нутгийн уур амьсгал нь эх газрын эрс тэс хахир ширүүн говь-цөлийн хүйтэвтэр-дулаавтар-хуурай, хахир хүйтэвтэр, халуун-хуурайдуу, дулаавтар-дулаан-хуурай ангид хамрагдах ба өвөл нь богиновтор, харьцангуй дулаавтар, цас багатай, хавар нь нэн хахир, шороон ба цасан шуургатай жаварлаг, дулааны эргэлт эрчимтэй, салхитай, нэн хуурай, хур чийг хамгийн бага байдаг онцлогтой. Зун нь урт халуун хуурай, зарим хэсэгтээ бүгчим, хур тунадас хавраас ихсэж зуны сүүлчээр хур бороо орох боловч 50-200мм, үүнээс бага, хөрс газрын 60-70°C хүрч хална. Намар нь хур бороо хэвийн хэмжээнд орвол зуншилга сайн, аажим сэргүүсдэг, газрын гүн рүү дулаан эрчимтэй нэвчдэг. Хөлдөлтийн гүн бага, хавар хэдхэн хоногт нарны илч, гүний дулааны нөлөөгөөр гүехэн 1-2м хөлдүү хөрс гэсдэг байна [1].

Геологи, геоморфологи. Өмнөговь аймгийн Ханбогд сүм нь Юрийн эхэн, дунд үеийн палеогеоморфологийн схем (Николаева, Шувалов, 1995)-ээр Тектоник-элэгдлийн хотгор гүдгэрийн Нам уулын хэв шинжид хамаарна. Тектоник-элэгдлийн гаралтай хотгор гүдгэрийн Шовх оройтой, эгц хажуутай, хэрчигдэл ихтэй, дундаж өндөр уулсын дэд хэв шинжид хамаарна[1].

Гадаргын ус болон газрын доорх ус. Өмнөговь аймгийн Ханбогд сүм нь Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Галба-Өвөш-Долоодын говийн сав газарт хамаарна. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав нь Монгол орны баруун, баруун өмнөд ба өмнөд хэсгийг хамрах бөгөөд Хангайн өвөрба баруун, Хэнтийн өмнөд хажуу, Монгол Алтайгаас эх авах голууд, өмнөд хэсгийн гол горхиуд болон том нууруудыг хамарна. Ай савын хүрээнд Хар нуур-Ховд, Булган, Үенч-Бодонч, Хяргас нуур-Завхан, Увс нуур-Тэс, Онги, Таац, Бөөн цагаан нуур-Байдраг, Орог нуур-Түй, Хүйсийн говь-Цэцэг нуур, Умард говийн гүвээт-Халхын дундад тал (Жаргалант гол), Галба-Өвөш-Долоодын говь (Баруун, Дунд, Баянгийн булаг), Алтайн Өвөр говь (Сагсай гол, Баян гол) гэсэн 13 сав газар болгож ангилсан байна[1].

Хөрсөн бүрхэвч. Төсөл хэрэгжих Цагаанхад орчмын бүс нутаг нь цөлжүү хээр болон цөл (говь) бүхий экосистемтэй учраас Борсаарал хэвшинжид багтах чулуурхаг, сайргархаг, элсэн хучаастай төрлийн хөрснүүд тархсан байна. Эдгээр хөрснөөс хэвшинжийн хувьд Борсаарал хөрс зонхилох бөгөөд төрлийн түвшинд чулуурхаг ба сайргархаг төрлийн хөрснүүд давамгайлна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимиин түвшин маш бага буюу ялзмагийн агууламж нь 0.4-0.9%, нимгэн үе давхаргатай, хүний нөлөөтэй эвдрэл талхагдалд амархан өртдөг, эргэж нөхөн сэргэхдээ маш удаан байна.

Ургамлын аймаг. Төслийн талбай нь ургамал газарзүйн тойргоор Алашаан говийн цөлийн тойротг хамаардаг (Өлзийхутаг, 1989). Алашаа говийн цөлийн тойротг нь Тост уулын өврөөс эхлээд зүүн тийш Борзон говь, Галбын говийг дамжин Сулинхээр хүртэлх нарийн зурvas газрыг багтаана. Алашаа говьд тойргийн хойд хэсгээс урагшлахад намсдаг хэвгийг гадаргатай. Газрын гадаргын хувьд бэсрэг уулс, хотгор хотос, тойром, цав толгод, ухаа гүвээ ээлжлэн солигдохын зэрэгцээ

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

умраас өмнийг чиглэсэн хуурай сайд, садрагууд олонтой юм. Бор бударгана, багалуур, хойрго, хотир, шар мод, боролзой, улаанбударгана, заг хармаг зонхилон ургадаг. Элсэнцэр цөлөөс гадна чулуурхаг цөл нэлээд их тааралдана. Марцлаг элстэй хотгоороор нь сибирь хармаг оролцсон загт цөлтэй. Манхан элстэй газраар нь *Hedysarum fruticosum*, *H.scoparium*, *Atriplex frutescens*, *Caragana bungei*, *C. Korshinskyi* зэрэг сөөглөг ургамал тохиолдоно.

Амьтны аймаг. Төслийн талбай орчим нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Алтайн өвөр говийн тойротг хамарагдаж байна. Төслийн талбай нь говийн нам уулс, толгод хоорондын хөндий хотос газарт байрлана. Төслийн талбай орчимд нөлөөлөл үүсгэж байгаа Цагаан хадны суурин, тээврийн хөдөлгөөн, хатуу хүчилттай зам зэргийн нөлөөгөөр амьтдын амьдрах орчин хуваагдаж, амьтдын тархац нутаг хумигдсан бөгөөд тус төслийн талбай орчимд томоохон хөхтөн амьтад (хар сүүлт, махчин амьтад)-ын тохиолдоц байхгүй. Харин жижиг хөхтөн амьтад болох чичүүл, алаг даага зэрэг тохиолдоно. Мөн талбай орчимд шувуудаас хээрийн бор шувуу *Passer montanus*, хон хэрээ *Corvus corax*, шоорон эвэрт болжмор *Eremophila alpestris* зэрэг шувууд тохиолдоно.

Өмнөговь аймаг. Өмнөговь аймаг нь 1923 оны дундуур хуучин дөрвөн аймгийг өөрчлөн байгуулах Засгийн газрын шийдвэр, мөн аймгийн захиргаа байгуулах дүрмийг батлан гаргажээ. Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарьт өөрчлөлт оруулах тухай шийдвэр 1928 оноос эхлэн шат дараалан гарчээ. Аймаг, хошуудын газар нутгийн хэмжээ асар уудам, газрын дундажийг олж төлөвлөж чадаагүй зэргийг харгалзан 1931 онд орон нутгийн засаг захиргааны бүтцийн өөрчлөлтийг хийсэн байна. Энэ өөрчлөлтөөр урьд нь 5 аймаг, 72 хошуу, 525 сум байсныг 12 аймаг, 324 сум болгон хуваахад Өмнөговь аймаг шинээр байгуулагдсан байна. Өмнөговь аймаг нь урд талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа, Баяннуур аймгуудтай хиллэдэг бол хойд хэсгээрээ Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорнговь аймгуудтай хил залгаа оршдог. Аймгийн төв Даланзадгад хот нь нийслэл хотоос 570 км зайдай. Засаг захиргааны хувьд 15 сум, 59 багтай юм.

Ханбогд сум. Төсөл хэрэгжих Ханбогд сум нь анх 1924 онд Хадан хошууны Хар-Овооны бууцан дээр ганц бор гэртэй Галба сум нэртэйгээр байгуулагдаж, анхны даргаар нь Д.Үржинзанги томилогдон ажиллаж байжээ. 1941 оны зүн нутгийн гүнд байдаг “Их булаг” гэдэг газарт нүүн ирж, “Ханбогд” хайрханыхаа нэрээр нэрлэж, одоог хүртэл энэ газартаа суурьышсаар байна. 1950-иад оны сүүлчээр ардын аж ахуйтны нэгдэл бүрэн хамрагдсан. Ханбогд сум нь нийт 15,150 км² газар нутагтай бөгөөд Номгон, Гавилууд, Жавхлант, Баян, Хайрхан гэсэн 5 засаг захиргааны нэгжид хуваагддаг. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 130км, аймгийн төвөөс 252км, нийслэл Улаанбаатар хотоос 600км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баян-Овоо, хойд талаараа Манлай, Цогцэций сумд, зүүн талаараа Дорнговь аймгийн Хатанбулаг сүмтэй хил залгана. 1515.1 км² нутаг дэвсгэртэй. Сумын нутаг дэвсгэрт Ханбогд, Жавхлант, Алагбаян, Сангатай, Хоёрхасар, Галба, Гавилуут зэрэг өндөрлөг бэсрэг уул нуруутдай, 100-130 км үргэлжилсэн Галбын говь, Дайчингийн говь, Сэвхүүлийн хоолойн элсэн далан, заган шугуй, Уртын гол, Үндайн гол, Халzan Хайлаастын гол гэх зэрэг хайлаасан зурvasuudтай, янз бүрийн хэлбэр дурс бүхий боржин чулуун цохиотой. Тогоо, Гурван зээрд, Ухаа Аргалантын агуинууд зэрэг байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Нийт 15 га талбайн 3 га талбайд ажилчдын кемп, 3 га талбайд авто зогсоол баригдаж, үлдсэн 9 га талбайд нүүрс ачиж буулгах талбай байгуулах зэрэг барилгын газар шорооны ажлын үед түр зуурын тоос тоосонцор үүсэх
- Нүүрс буулгах талбайн хашаа шаардлага хангаагүй бол салхи шуургатай үед нүүрсний овоолгоос нүүрсний нарийн ширхгүүд хийсэж орчин тойронд тоосжилт үүсэх (загварчлалын аргаар тооцоолж үзэхэд жилд нийт тоос 6,911.2кг, PM₁₀ тоосонцор 2,105.05 кг, үүсэж болзошгүй)
- Хэрэв нүүрс тээврийг задгай тэвшинд тээвэрлэх явцад битүүмжлэл, хүчлага хучаас мүү байвал салхины нөлөөгөөр орчин тойронд нүүрсний нарийн ширхгүүд хийсэж агаар орчинд сөргөөр нөлөөлнө. (загварчлалын аргаар тооцоолж үзэхэд тээвэрлэлтийн үед жилд нийт тоос 6,318 кг, PM₁₀ тоосонцор 3,186кг, PM_{2.5} тоосонцор 473.4 кг үүсэж болзошгүй)
- Төслийн үйл ажиллагаанд нийт 30 ш тээврийн хэрэгсэл ашиглах бөгөөд тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаарт нүүрстөрөгчийн дутуу болон давхар исэл ялгарах

3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Нийт 15 га талбайн 3 га талбайд ажилчдын кемп, 3 га талбайд авто зогсоол баригдаж, үлдсэн 9 га талбайд нүүрс ачиж буулгах талбай бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох
- Машин техникийн засвар үйлчилгээг зориулалтын бус газарт хийх үед шатах, тослох материалын асгаралт үүссэн тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох
- Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалаагүй болон тогтмол төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөвөрлөөгүйн улмаас хөрс бохирдох
- Ажилчдын ахуйн шингэн хаягдал, хөрс хамгаалах доторлогоогүй жорлонд бие зассанаар хөрс бохирдох

3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутагт гол мөрөн, нуур цөөрөм зэрэг гадаргын үс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагаанд ажилчдын үнд ахуйн усыг худгаас зөөвөрлөн ашиглах тул усан орчинд үзүүлэх шууд нөлөөлөл бага байна.

3.4 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбайн ургамлан нөмрөг нь үйл ажиллагааны нөлөөгөөр хүчтэй талхлагдсан бөгөөд эдэлбэр газрын зах хэсгээр бага зэргийн ургамалжилттай, эдэлбэрийн хойд болон төв хэсгээр, нүүрс ачиж буулгах, тээвэр зорчих зам талбайн ашиглалтаар газрын ургамлан бүрхэвч зайлуулагдаж устсан учраас ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГҮЙ

Премиум кастомс ХХК-ийн Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн 2024 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав. 2021 онд батлагдсан БОННҮ тайландаа БОМТ-г хэрэгжүүлэх 5 жилийн дундаж зардалд нийт 60,540,000 ₮ төсөвлөсөн бөгөөд 2024 оны БОМТ-г хэрэгжүүлэхдээ нийт **12,606,000 ₮** зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,470,000
2.	Орчны тохижилт нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,450,000
3.	Байгаль орчны хамгаалах төлөвлөгөө	2,220,000
4.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,980,000
5.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,000,000
6.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,486,000
	Нийт зардал	12,606,000

4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Премиум кастомс ХХК-ийн 2021 онд батлагдсан БОННҮ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт 13 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн 2024 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 4-2-д тусгав.

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1.	Талбайд нүүрс ачиж буулгах, хадгалах үед агаарт нүүрсний тоосжилт үүсэх	Тоосжилтын тархалтыг багасгахын тулд салхины хаалт төмөр хашааг байгуулах	Төслийн талбай	-	-	ҮА3*		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	-2021 оны БОННУ-ний тайлангийн 5.4.1-т тусгаснаар
2.		Тоосжилтыг багасгах үүднээс төслийг төслийн төлөвлөлтөд тусгагдсан талбай буюу орц, гарцын 3 га талбайг хайрган хүчилттай болгох	Талбайн орц, гарц	3	га	ҮА3*		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	-Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай, ЗГ-ын тогтоол
3.	Тээврийн хэрэгслийн түвшний шаталтаас агаарт SO _x NO _x тархах	Нүүрс тээвэрлэх тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд тогтмол хамруулах	North benz	30	ш	30,000	900,000	Жилд 1 удаа	-MNS:5011:2020. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)									
4.	Хөрс талхлагдах	Төслийн талбайн хашаан доторх байгууламж хооронд сайжруулсан шороон зам (хайрган хүчилт) байгуулах	Төслийн объектууд	-	-	ҮА3*		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

№	Гол болон болзошгүй сэрг нөлөөлүүд	Сэрг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
5.	Хөрсний бохирдол үүсэх	Болзошгүй байдлаар шатах тослох материал асгарсан үед хэрэглэх саармагжуулах иж бурдлийг байрлуулах	Пүү, гаалийн хяналтын байцаагч байрлах байр, оффис	2	ш	330,000	660,000	Жилд 1 удаа	-2021 оны БОНHY-ний тайлангийн 6.2.1-т тусгаснаар -Эрүүл ахуйн тухай хууль, 4.4.3
6.	Хөрс хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Төслийн талбай	12	удаа	50,000	600,000	Сард 1 удаа	
			орчны 50 м	4	удаа	50,000	200,000	Улиралд 1 удаа	
7.	Хөрс талхлагдах	Тээврийн хэрэгслийн зогсоолд хурдны хязгаарлалт болон зогсоолын тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	авто машины зогсоол	3	ш	30,000	90,000	Жилд 1 удаа	
Усан орчин									
8.	Шингэн хаягдлыг шууд хөрсөнд зайлуулснаар хөрс бохирдох	Хөрс бохирдуулахгүй бохирын ёмкость суурилах	оффис	ш	1	ҮАЭ*		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
9.	Усны хэт их хэрэглээ үүсэх	Усыг хэмнэх талаар зөвлөмжүүдийг байрлуулах	оффис	4	ш	5,000	20,000	Жилд 1 удаа	
Сэрг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал					2,470,000 ₮				

Тайлбар: ҮАЭ*- Үйл ажиллагааны зардалд тусгах

4.4 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл нь нийт 15 га талбайд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд Газрын тухай хуулийн 56.6-д тусгаснаар Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана гэсэн заалтын дагуу төслийн талбайн 10 хувь буюу 1.5 га талбайд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 шт модыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.

Энэхүү ажлын зардлыг төсөл хэрэгжүүлэгч Премиум кастомс ХХК нь үйл ажиллагааны зардалд тусгаж хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нэг ж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
	Суулгац авах		ш	200	Хавар, намрын улиралд	11,250	2,250,000	-Газрын тухай хуулийн 56.6
Ногоон байгууламж байгуулах	Мод тарих		ш	4		50,000	200,000	
		1.5 га			Мэргэжлийн байгууллагатай хамтран ямар мод тарьснаас шалтгаалан услах хэмжээг тооцоолно.		ҮА3*	-Мод тарих гарын авлага
						Нийт зардал	2,450,000 ₮	

4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологийн мэргэжлийн байгууллагаар уг газарт урьдчилан хайгуул, малтлага, судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна” гэж тусгасан байдаг. Төсөл хэрэгжих талбайн орчимд ямар нэгэн археологи, палеонтологийн судалгаа хийгдээгүй байна.

Иймд газрын хөрсөнд булагдсан дурсгал олдвор байхыг угүйсгэхгүй тул төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаа явуулах явцад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сүм, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллах нь зүйтэй.

4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Премиум кастомс ХХК-ийн 2021 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд нийт 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Премиум кастомс ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2024 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 2,220,000 ₮ зарцуулахаар байна.

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, серөг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Цар, хэмжээ	Тоо, хэмжээ	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачал
1	2	3	4	6	7	8	9	
1.		Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар зааварчилгааг мөрдүүлж ажиллах		-	-	-	Өдөр бүр	
2.	Хөдөлмөр ийн аюулгүй ажиллагаа алдагдах	Ажилчдыг ХАБЭА-н сургалтад хамруулах	ажилчид	4	500,000	2,000,000	Улиралд 1 Удаа	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль -Галын аюулгүй байдлын тухай хууль
3.		Аюулгүйн санамжийн самбар хийлгэж, байрлуулах	ажилчид	2	50,000	100,000	Жилд 1 Удаа	
4.	Гал түймэр	Гал түймрээс сэргийлэх, багаж хэрэгсэл, галын хорыг байрлуулах	гальян булан	2	60,000	120,000	Жилд 1 Удаа	
Нийт зардал					2,220,000 ₮			

4.7 ХОГ ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Премиум кастомс ХХК-ийн 2021 онд батлагдсан БОННҮ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд нийт 6 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Премиум кастомс ХХК нь 2024 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 1,980,000 ₮ зарцуулахаар байна.

Хүснэгт 4-5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын антлагал	Серөг нөлөөллийг арилгах, бууруулах арга	Хамрах хүрээ	Тоо	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх эүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Aхуйн	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлэх	Төслийн талбай	12 удаа	40,000	480,000	Сард 1 удаа		-Хог хаягдлын тухай хууль
2.		Хог хаягдлын бүртгэл хөтлөх	-		Зардал гарахгүй		Өдөр бүр		



Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

№	Хог хаягдлын аngилал	Сэрг нээвлийн йг арилтах, бүрүулах арга	Хамрах хүрээ	Тоо	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3.	Ангилан ялгалттай хогийн сав байрлуулах	Төслийн талбай	1	Ш	1,500,000	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	1,980,000 ₮		
Нийт зардал									

4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиригаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний чухал хэсэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1.5-т зааснаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн 2024 оны үйл ажиллагааны явцад Хүснэгт 4-6-д тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг доорх хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Премиум кастомс ХХК нь төслийн үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор хөрс, үндны усны шинжилгээг улиралд 1 удаа хийхийг зөвлөж байна. Харин гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэж, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэж байх хэрэгтэй. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Премиум кастомс ХХК бүрэн хариуцна.

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

Хүснэгт 4-6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	
Агаарын чанар							
1.	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаарын температур, чийгшил 	Нүүрс ачиж буулгах талбай, оффис	2	Улиралд 1 удаа (жилд 4 удаа)	300,000	1,200,000	MNS.4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын чанар (хөндлөнгийн хяналт)							
	<ul style="list-style-type: none"> Орчны тоосжилт (PM_{2.5}, PM₁₀ TSP) Агаар бохирдуулагч хий (SO₂, NO₂) Дуу чимээ 	Нүүрс ачиж буулгах талбай, оффис	3	Жилд 1 удаа	ҮАЗ*		MNS.3384:1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорыц авахад тавих ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч							
3.	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физикийн ерөнхий шинижилгээ 	Нүүрс ачиж буулгах талбай, оффис	2	Улиралд 1 удаа (жилд 4 удаа)	30,000	240,000	MNS.2305:1995. Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх
Хөрсөн бүрхэвч (хөндлөнгийн хяналт)							
	<ul style="list-style-type: none"> Хөрсний хими болон физик Хүнд металл 	Нүүрс ачиж буулгах талбай, оффис		Жилд 1 удаа	ҮАЗ*		MNS.5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усан орчин (хөндлөнгийн хяналт)							
5.	<ul style="list-style-type: none"> Ажилчдын ундны усыг 	оффис		Жилд 1 удаа	46,000	46,000	MNS.6230:2010. Бохир ус зайлцуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага
Нийт зардал						1,486,000 ₮	

Тайлбар: ҮАЗ*- Үйл ажиллагааны зардалд тусгах

4.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Премиум кастомс ХХК-ийн 2021 онд батлагдсан БОННҮ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд нийт 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Премиум кастомс ХХК нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10^1 дэх заалт болон Ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу 2024 онд байгаль орчны аудитыг хийлгэх шаардлагатай.

2024 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг Хүснэгт 4-7-д тусгав.

Хүснэгт 4-7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Үрьдчилан тооцсон төсөв сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	
			2024 он				
			IV	VIII	XII		
1	2	3	4	5	6		
1.	Байгаль орчны аудитыг хийлгэх	4,000,000	+			Удирдлага	
2.	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулах	ҮАЗ*		+		ХАБЭА ажилтан	
3.	Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Өмнө аймгийн БОАЖГ-т хүргүүлэх	-			+	Хариуцсан мэргэжилтэн	
Нийт зардал					4,000,000 ₮		

Тайлбар: ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах*

4.9.1 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БУСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, БОАЖЯ-нд батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор Өмнөговь аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ.

2024 он БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарийг Хүснэгт 4-8-д тусгав.

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

Хүснэгт 4-8. БОМТ-ний хэрэгжилтийг тайллагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч тaluуд	Тайллагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тov	Тайллагнах зардал, ₮	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан		Зохион байгуулах газар
						1	2	3
1.	Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Хэвлэмэл	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг тусгасан тайлан байна. Ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажса н байна.	11 дүгээр сарын 01- нээс өмнө	Удирдлага болон Байгаль орчны мэргэжилтэн	УА3*		Өмнөговь аймаг
2.	БОАЖЯ	Байгаль орчны мэдээллий н санд цахимаар (www.eic.mn)	Тухайн жил хийх ажлын төлөвлөгөө	12 дугаар сарын 30- наас өмнө			УБ хот	

Премиум кастомс ХХК нь жил бүр БОМТ боловсруулан БОАЖЯ-аар батлуулж, БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ханган биелүүлж, БОМТ-ний биелэлтийн тайланг жил бүр Өмнөговь аймгийн БОАЖГ-т хүргүүлэх үүрэгтэй.

ДҮГНЭЛТ

Премиум кастомс ХХК-ийн Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн 2024 оны БОМТ-г боловсруулан дараах дүгнэлтийг хийж байна.

- Гаалийн хяналтын талбай байгуулах төслийн 2024 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 2,470,000 ₮, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 2,220,000 ₮, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 2,450,000 ₮, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 1,980,000 ₮, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 1,486,000 ₮, удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2,000,000 төгрөг тус тус төсөвлөв.
- Премиум кастомс ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 12,606,000 ₮ зарцуулан 24 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөлөө.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хавсралтын нэр	Хуудас
1.	Төлөвлөгөө хянасан мэргэжилтний шүүмжийн хариу	1
2.	Эрх бүхий албан тушаалтны даалгавар, шийтгэлийн хуудас, төлбөрийн баримт	3

ХАВСРАЛТ №1

№	Шүүмж	Тайлбар
1.	2024 оны төлөвлөгөөг аймгийн БОАЖГ-аар хянуулж, саналыг тусгах	2024 оны БОМТ-г Өмнөговь аймгийн БОАЖГ-аар хянуулж төслийн талбайг шалгуулсны үндсэн дээр Байгаль орчны улсын байцаагчийн 2024.03.26-ний өдрийн № 0854721 тоот шийтгэлийн хуудсаар оногдуулсан мөнгөн төлбөрийг 2024.04.06-ний өдөр Өмнөговь аймгийн хүү торгуулийн орлогын дансанд төлж барагдуулсан болно. (Эрх бүхий албан тушаалтны даалгавар, шийтгэлийн хуудас, төлбөрийн баримт зэргийг доор хавсаргав.)
2.	БОНHY-ний 5 жилийн тайланд БО-г хамгаалах зардалд 60,540,000 ₮ төсөвлөсөн. 2024 оны БОМТ-ний зардалд 10,446,000-г төлөвлөсөн нь уялдахгүй байна, уялдуулах	2024 оны БОМТ-ний 4.2-р хэсэгт (4-1-р хуудас) тусгав.
3.	<ul style="list-style-type: none">Төслийн талбайн ачиж буулгах талбайн өнөөгийн бодит фото зургийг ирүүлэхБОНHY-ний тайланд тусгасан "Тоосжилтыг багасгах үүднээс төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн төлөвлөлтөд тусгагдсан талбайг хатуу хүчилттай болгох" ажил 2024 оны төлөвлөгөөнд тусаагүй байна, тусгах (нийт хэдэн га талбайгаас орц гарцын хэдэн га-г 2024 онд хатуу хүчилттай болгох талаар тодорхой тусгах)	<ul style="list-style-type: none">Төслийн талбайн өнөөгийн фото зургийг БОМТ-ний 1.2.2 Төслийн талбайн байгууламж (1-2-р хуудас) хэсэгт тусгав.Төслийн талбай нийт 15 га бөгөөд үүнээс 3 га талбай нь орц, гарц (1-3-р хуудас) байх бөгөөд тухайн талбайг хайрган хүчилттай болгохоор төлөвлөлөө.
4.	Хатуу хүчилттай болгох төсөв зардал боломжгүй, хугацаа бага байвал орц гарцыг хайрган хүчилттай болгохоор төлөвлөгөөнд тусгаж болно. 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг хянахад энэ ажлыг онцгой анхаарч тайланг нь батлах учраас анхаарч төлөвлөх	<ul style="list-style-type: none">Төслийн талбай нийт 15 га бөгөөд үүнээс 3 га талбай (БОМТ-ний 1.2.2-т тусгаснаар) нь орц, гарц байх бөгөөд тухайн талбайг хайрган хүчилттай болгохоор төлөвлөлөө. (4-2-р хуудас)
5.	40 ш мод тарина гэж төлөвлөсөн байна, мод ургах эсэхийг аймгийн БОАЖГ-тай зөвшилцэж төлөвлөх.	Өмнөговь аймгийн БОАЖГ-ын Оргилмаа мэргэжилтэнтэй ярьж зөвшилцсөний үндсэн дээр ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгасан модны тоог нэмж төлөвлөлөө.

ХАВСРАЛТ №2

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ДААЛГАВАР
“ПРЕМИУМ КАСТОМС ХХК”-Д

2024 он 03 дугаар сарын 26 Дугаар: 2024/

Даланзадгад сум Өмнөговь

аимгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны улсын байцаагч
Д.Ичинноров би, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан
зөрчил үйлдсэн зөрчлийн холбогдолтой 9011722073 улсын бүртгэлийн регистрийн 6274463
дугаартай Премиум кастомс ХХК-д холбогдох зөрчил болох

1. Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 3-т /Байгаль орчинд нөлөөлөх
байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй
тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний
төгрөгөөр торгоно./ заасан заалтыг зөрчсөн байх тул 2024 оны 03 дугаар сарын 26-ны
өдрөөс 30 хоногийн дотор байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж, Байгаль орчинд
нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ
биелүүлэх, зөрчлийн үр дагаварагыг арилган ажиллах, тортготийг 2024 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн дотор Төрийн сан банкин дахь Өмнөговь хүү тортготийн орлогын
100110000988 тоот дансанд 3.000.000 төгрөгийг төлөхийг холбогдолтой Премиум кастомс
ХХК-д даалгасугай

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН: /Д.ИЧИННОРОВ /
(гарын үсэг) (нэр)

ДААЛГАВРЫГ ХҮЛЭЭН АВСАН / Ч.БАТ-ЭРДЭНЭ /
(гарын үсэг) (нэр)

Гаалийн хяналтын талбай байгуулах төсөл
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – 2024 он

..... оны сарын өдөр хот, сум

Засгийн газрын 2021 оны
135 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт:

ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)
№ 0854721

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД
ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

Онцгайрь ажилшии Эдүгээ Тогтолцоогийн /эрх бүхий албан тушаалтын харьяалах байгууллага, ажил, нэр, цол, зэрэг/ шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дахь хэсэгт заасан /.../ асуудлыг шалгаад ОЛСОН нь:
Холбогдох /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр/ хүний /овог, нэр, рөгистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг /.../ болох нь зэрэг ноглоо баримтаар нотлогдсон тогтоогдох, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна. 7/ Иймд холбогдох /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн зүйлийн -д заасан шийтгэл оногуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ: 100,000 /100 000 000 98/

1. Холбогдох /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдэсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл оногуудсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, хохирол, нөхөн төлбөрийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг /улсын төсөвт/ Төрийн сангийн тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бэлэнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн /үйлажиллагаа, эрх/аль болохыг зурах/-ыг хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох /аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногуулсугай.

4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан төгрөгийн торгуулийн шийтгэлийг хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:
А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/
Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, тэзвэрийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/
В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/ /аль нь болохыг доогуур зурах/ /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-т Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн толыулэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу

..... шийдвэрлэсүгэй.

6. Холбогдох /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар -ны өдрийн дотор үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдээн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрлийг биелүүлэгчийг бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан: /..... /
ТАНИЛЦСАН:

Холбогдох, хууль ёсны төлөөлөгч: /..... /
..... оны сарын өдөр (гарын усэг) (нэр)
..... оны сарын өдөр (гарын усэг) (нэр)

..... оны сарын өдөр (гарын усэг) (нэр)



Огноо/Date: 2024.04.29 16:33:34

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000706119561

Системийн огноо/System Date: 2024.04.06 15:40:03

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5070621101	ПРЕМИУМ КАСТОМС	3,000,000.00 MNT	1.00
/ Гурван сая төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No	Банкны нэр Bank Name		
	90	Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name		
	100110000988	Өм.Хүү, торгуулийн орлого	3,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-Байгаль, орчин аялал жуулчлалын газрын улсын байцаагчийн илэрүүлсэн зөрчилд ноогдуулсан торгууль.

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)